

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/25/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЧАНДМАНЬ СУМАН ДАХЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН
2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarijargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Майцэцэг

Утас: 70273204 Цахим хаяг: maitsetsegt@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэгч: Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК

Утас: 99884842 Цахим хаяг: gereltekhburtgelaudit02@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
4. Аудитын илрүүлэлт	19
4.1 Залруулсан алдаа.....	19
4.2 Төлбөрийн акт.....	19
4.3 Албан шаардлага	20
4.4 Зөвлөмж.....	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НХМ	Нэг хэвийн маягт
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг
Утас: 70272248, Факс: 70272582, И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/68
танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехник коллежийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехник коллежийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖИГ **19020262**

D 2022/2022 он/ALBAN BICHIG

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	235,275,928.85	248,339,255.51
33	АВЛАГА	13,363,933.87	4,069,658.50
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	29,040.47
335	Бусад авлага	13,363,933.87	4,040,618.03
3351	Байгууллагаас авах авлага	4,853,622.87	242,941.03
3352	Хувь хүмүүсээс авах авлага	8,510,311.00	3,797,677.00
35	БАРАА МАТЕРИАЛ	221,911,994.98	244,269,597.01
351	Түүхий эд материал	111,142,084.46	127,257,193.86
35110	Тусгай зориулалттай материал	109,366,184.46	125,510,285.86
35130	Эм боох материал	1,775,900.00	1,746,908.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	8,450,800.00	15,855,500.00
354	Хангамжийн материал	72,487,560.52	68,974,453.15
35410	Бичиг хэргийн материал	1,924,710.00	1,603,643.00
35420	Аж ахуйн материал	27,482,305.35	26,565,636.98
35430	Сэлбэг хэрэгсэл	1,298,500.00	00.00
35450	Барилгын засварын материал	18,203,040.65	18,143,130.65
35460	Хүнсний материал	3,212,109.12	315,467.12
35470	Бусад хангамжийн материал	20,366,895.40	22,346,575.40
35500	Биологийн хөрөнгө	5,491,550.00	5,912,450.00
35600	Мал амьтад	24,340,000.00	26,270,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,509,054,543.52	6,421,126,801.31
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,509,054,543.52	6,421,126,801.31
392	Биет хөрөнгө	3,903,043,543.52	5,815,268,801.31
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,782,304,683.00	3,578,607,898.47
39202	Хуримтлагдсан элэгдэл	(493,762,172.68)	(678,980,673.52)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	440,273,060.00	408,723,060.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(246,285,913.42)	(252,148,804.76)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,370,515,134.10	1,862,008,180.10
39206	Хуримтлагдсан элэгдэл	(158,247,676.43)	(295,530,148.31)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	112,573,843.00	134,824,243.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(56,404,728.00)	(75,591,292.07)
39214	Бусад үндсэн хөрөнгө	331,781,256.00	1,353,635,147.22
39215	Хуримтлагдсан элэгдэл	(204,662,062.42)	(245,236,929.19)
39217	Ном	24,958,120.37	24,958,120.37
393	Биет бус хөрөнгө	606,011,000.00	605,858,000.00
39301	Програм хангамж	5,335,000.00	5,643,000.00
39302	Хасагдуулга	(2,174,000.00)	(2,635,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	602,850,000.00	602,850,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,744,330,472.37	6,669,466,056.82
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,777,921.86	3,041,241.50
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,777,921.86	3,041,241.50
413	Өглөг	796,892.86	1,788,359.99
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	796,892.86	1,999.99
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	1,786,360.00

Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехник коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

4136	Бусад өглөг	1,981,029.00	1,252,881.51
41361	Байгууллагад төлөх өглөг	703,252.00	1,050,465.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,277,777.00	202,416.51
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,741,552,550.51	6,666,424,815.32
51	Засгийн газрын хувь оролцоо	4,741,552,550.51	6,666,424,815.32
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,621,251,717.46	1,621,251,717.46
51101	Өмч: - төрийн	1,034,401,717.46	1,034,401,717.46
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	586,850,000.00	586,850,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	446,980,481.60	2,371,852,746.41
51210	Өмнөх үеийн үр дүн	446,980,481.60	446,980,481.60
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,924,872,264.81
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,673,320,351.45	2,673,320,351.45
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,744,330,472.37	6,669,466,056.82

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,480,474,060.05	4,595,640,246.69
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	906,535,060.05	2,409,070,146.69
120	Нийтлэг татварын бус орлого	906,535,060.05	2,409,070,146.69
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	418,290.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,946,217.95	5,975,754.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	00.00	8,130,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	853,279,342.10	2,394,546,102.69
120009	Бусад орлого	42,309,500.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,573,939,000.00	2,186,570,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,573,939,000.00	2,186,570,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,573,939,000.00	2,186,570,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,599,050,084.59	2,668,483,982.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,599,050,084.59	2,668,483,982.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,529,697,824.59	2,479,849,245.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	698,402,958.00	1,121,794,790.60
210101	Үндсэн цалин	479,993,128.81	706,575,062.17
210102	Нэмэгдэл	172,034,881.89	275,742,862.64
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,312,893.30	41,287,803.45
210104	Урамшуулал	21,062,054.00	98,189,062.34
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	86,353,903.77	144,446,646.77
210201	Тэтгэврийн даатгал	59,394,464.84	101,530,240.29
210202	Тэтгэмжийн даатгал	7,189,075.19	11,155,551.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,584,517.46	8,924,441.15
210204	Ажилгүйдлийн даатгал	1,289,621.48	2,076,037.62
210205	Эрүүл мэндийн даатгал	12,896,224.80	20,760,375.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	312,618,554.00	493,521,942.00

Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехник коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210301	Гэрэл, цахилгаан	33,805,554.00	46,796,042.00
210302	Түлш, халаалт	278,813,000.00	446,725,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,044,358.95	41,280,099.37
210401	Бичиг хэрэг	1,669,534.00	2,828,127.00
210402	Тээвэр, шатахуун	7,067,190.04	16,563,980.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,209,370.61	4,489,114.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,329,200.00	3,961,070.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,659,064.30	9,842,238.37
210408	Бараа материал акталсны зардал	2,110,000.00	3,595,570.00
2105	Нормативт зардал	43,765,660.00	97,780,899.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,424,950.00	1,936,492.00
210502	Хоол, хүнс	39,340,710.00	94,314,407.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		1,530,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46,634,005.00	25,185,240.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	1,239,600.00
210604	Урсгал засвар	46,634,005.00	23,945,640.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,646,575.00	58,729,849.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	41,246,925.00	54,576,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	718,460.00	677,249.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,116,190.00	818,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	217,800.00	493,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	347,200.00	165,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	274,231,809.87	497,109,778.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,275,556.00	30,700,630.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	27,627,838.00	46,657,853.60
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	235,328,415.87	419,751,295.28
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,352,260.00	188,634,736.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	69,352,260.00	182,512,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,882,360.00	112,096,700.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	45,969,900.00	67,972,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	2,443,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	6,122,136.64
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	6,122,136.64
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	881,423,975.46	1,927,156,264.43
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	1,000,100.00	00.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	1,000,100.00	00.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	14,256,000.00	2,283,999.62
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	384,999.62
225002	Найдваргүй авлагын алдагдал	00.00	1,899,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	14,256,000.00	00.00

Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехник коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(13,255,900.00)	(2,283,999.62)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>868,168,075.46</u>	<u>1,924,872,264.81</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
CO 1	2020 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	1,034,401,717.46	736,650,433.78	(273,218,078.15)	1,497,834,073.09
CO 2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
CO 3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,034,401,717.46	736,650,433.78	(273,218,078.15)	1,497,834,073.09
CO 4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
CO 5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
CO 6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
CO 7	Тайлант үеийн үр дүн	586,850,000.00	-	(105,342,260.56)	481,507,739.44
CO 8	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,621,251,717.46	2,673,320,351.45	446,980,481.60	4,741,552,550.51
DO 1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,621,251,717.46	2,673,320,351.45	446,980,481.60	4,741,552,550.51
DO 2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
DO 3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,621,251,717.46	2,673,320,351.45	446,980,481.60	4,741,552,550.51
DO 4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
DO 5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
DO 6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-

D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	1,924,872,264.81	1,924,872,264.81
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,621,251,717.46	2,673,320,351.45	2,371,852,746.41	6,666,424,815.32

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,208,100,792.00	2,203,135,106.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,696,892.00	16,565,006.00
120	Нийтлэг татварын бус орлого	14,696,892.00	16,565,006.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14,696,892.00	16,565,006.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	299,500.00	418,290.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,397,392.00	8,016,716.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	00.00	8,130,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,193,403,900.00	2,186,570,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,193,403,900.00	2,186,570,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,193,403,900.00	2,186,570,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,197,936,092.00	2,198,497,106.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,197,936,092.00	2,198,497,106.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,954,133,833.07	2,009,862,369.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,044,641,328.01	1,120,830,920.90
210101	Үндсэн цалин	653,562,674.69	710,390,807.45
210102	Нэмэгдэл	312,863,976.02	273,606,127.97
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,855,443.30	41,558,006.70
210104	Урамшуулал	45,359,234.00	95,275,978.78
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	128,443,475.06	144,534,771.46
210201	Тэтгэврийн даатгал	88,215,313.70	101,705,047.17
210202	Тэтгэмжийн даатгал	10,470,851.45	10,769,370.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,359,875.22	8,605,376.14
210204	Ажилгүйдлийн даатгал	1,952,912.46	2,128,183.26
210205	Эрүүл мэндийн даатгал	19,444,522.23	21,326,794.63
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	505,613,108.00	493,521,942.00
210301	Гэрэл, цахилгаан	47,262,108.00	46,796,042.00
210302	Түлш, халаалт	458,351,000.00	446,725,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	46,456,939.00	34,801,914.00
210401	Бичиг хэрэг	2,659,800.00	2,488,200.00
210402	Тээвэр, шатахуун	10,243,000.00	14,054,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,388,139.00	4,497,114.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	16,651,500.00	6,386,400.00

Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехник коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,514,500.00	7,375,400.00
2105	Нормативт зардал	93,772,535.00	89,331,975.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,303,300.00	1,738,700.00
210502	Хоол, хүнс	86,531,935.00	84,250,975.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,937,300.00	3,342,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,891,000.00	24,686,220.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,347,000.00	2,252,700.00
210602	Тавилга	00.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	411,300.00	329,600.00
210604	Урсгал засвар	13,132,700.00	22,103,920.00
2107	Томилолт, зочны зардал	776,000.00	00.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	776,000.00	00.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	70,000,848.00	59,852,026.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	55,198,498.00	55,853,777.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,419,200.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	718,460.00	677,249.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,116,190.00	818,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	217,800.00	352,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	530,700.00	149,600.00
210807	Газрын төлбөр	9,800,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49,538,600.00	42,302,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	49,538,600.00	42,302,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	243,802,258.93	188,634,736.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	121,168,860.00	182,512,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,882,360.00	112,096,700.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	96,846,500.00	67,972,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,440,000.00	2,443,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	122,633,398.93	6,122,136.64
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	122,633,398.93	6,122,136.64
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	10,164,700.00	4,638,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	10,164,700.00	4,638,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,164,700.00	4,638,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,164,700.00	4,638,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,164,700.00	4,638,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-10,164,700.00	-4,638,000.00

Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехник коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,200,570,100.00	2,188,893,469.36	11,676,630.64	99.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,200,570,100.00	2,188,893,469.36	11,676,630.64	99.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,018,057,500.00	2,006,380,869.36	11,676,630.64	99.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,114,887,700.00	1,114,830,920.90	56,779.10	100.0
210101	Үндсэн цалин	704,393,400.00	704,390,807.45	2,592.55	100.0
210102	Нэмэгдэл	273,625,500.00	273,606,127.97	19,372.03	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	41,580,000.00	41,558,006.70	21,993.30	99.9
210104	Урамшуулал	95,288,800.00	95,275,978.78	12,821.22	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	150,134,700.00	143,724,771.46	6,409,928.54	95.7
210201	Тэтгэврийн даатгал	107,039,800.00	100,895,047.17	6,144,752.83	94.3
210202	Тэтгэмжийн даатгал	10,773,700.00	10,769,370.26	4,329.74	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,619,000.00	8,605,376.14	13,623.86	99.8
210204	Ажилгүйдлийн даатгал	2,154,700.00	2,128,183.26	26,516.74	98.8
210205	Эрүүл мэндийн даатгал	21,547,500.00	21,326,794.63	220,705.37	99.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	498,172,000.00	493,521,942.00	4,650,058.00	99.1
210301	Гэрэл, цахилгаан	51,446,100.00	46,796,042.00	4,650,058.00	91.0
210302	Түлш, халаалт	446,725,900.00	446,725,900.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	34,063,200.00	33,965,414.00	97,786.00	99.7
210401	Бичиг хэрэг	1,821,200.00	1,821,200.00	-	100.0

Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехник коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210402	Тээвэр, шатахуун	13,554,800.00	13,554,800.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,485,400.00	4,387,614.00	97,786.00	97.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,386,400.00	6,386,400.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,815,400.00	7,815,400.00	-	100.0
2105	Нормативт зардал	89,660,000.00	89,331,975.00	328,025.00	99.6
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,738,700.00	1,738,700.00	-	100.0
210502	Хоол, хүнс	84,579,000.00	84,250,975.00	328,025.00	99.6
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,342,300.00	3,342,300.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,428,600.00	27,428,220.00	380.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,994,700.00	4,994,700.00	-	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	329,600.00	329,600.00	-	100.0
210604	Урсгал засвар	22,104,300.00	22,103,920.00	380.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	60,260,700.00	60,127,026.00	133,674.00	99.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	55,946,200.00	55,853,777.00	92,423.00	99.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	718,500.00	677,249.00	41,251.00	94.3
210804	Тээврийн хэрэгслийн татвар	818,600.00	818,600.00	-	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	352,800.00	352,800.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	424,600.00	424,600.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,450,600.00	43,450,600.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	43,450,600.00	43,450,600.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	182,512,600.00	182,512,600.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	182,512,600.00	182,512,600.00	-	100.0

Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехник коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	112,096,700.00	112,096,700.00	-	100.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	67,972,900.00	67,972,900.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,443,000.00	2,443,000.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	854,771,300.00	854,771,300.00	-	100.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,186,570,100.00	2,186,570,100.00	-	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,186,570,100.00	2,186,570,100.00	-	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	14,000,000.00	8,435,006.00	5,564,994.00	60.3
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	418,290.00	4,581,710.00	8.4
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,000,000.00	8,016,716.00	983,284.00	89.1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	79.00	79.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	44.00	44.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	34.00	34.00	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,130,000.00	8,119,500.00	10,500.00	99.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,130,000.00	8,119,500.00	10,500.00	99.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,130,000.00	8,119,500.00	10,500.00	99.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,000,000.00	6,000,000.00	-	100.0
210101	Үндсэн цалин	6,000,000.00	6,000,000.00	-	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	810,000.00	810,000.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	810,000.00	810,000.00	-	100.0

2104	Хангамж, бараа материалын зардал	1,320,000.00	1,309,500.00	10,500.00	99.2
210401	Бичиг хэрэг	700,000.00	700,000.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	500,000.00	500,000.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	120,000.00	109,500.00	10,500.00	91.3
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,130,000.00	8,130,000.00	-	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	8,130,000.00	8,130,000.00	-	100.0
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	8,130,000.00	8,130,000.00	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	79.00	79.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	44.00	44.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	34.00	34.00	-	100.0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехник коллежийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгийн ашиглалт, цалингийн тооцоолол, татварын хуулийн хэрэгжилт, шилэн дансны хэрэгжилт, МУЗГ-ын 43 дугаар тогтоолын хэрэгжилтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-ийн ахлах аудитор С.Дашдэндэв, аудитор Д.Галт-Эрдэнэ, аудиторын туслах Э.Алтангэрэл, аудиторын туслах Ч.Мөнхбаясгалан нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Д.Батмөнх, захирал А.Сарангэрэл, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, Дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехник коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехник коллеж нь Мэргэжлийн боловсрол олгох, мэргэжлийн сургалт олгох, техникийн боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа байгууллага юм.

Эрхэм зорилго: "Иргэний авьяас, сонирхол, хөдөлмөр эрхлэх хэрэгцээнд тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн мэргэжлийн ур чадвар, боловсрол эзэмшүүлэх, мэргэшлийг дээшлүүлэх, хөдөлмөрийн болон харилцааны соёл төлөвшүүлэхэд оршино" гэж заасан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехник коллеж нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 1.0 хувиар буюу 25,983.1 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 19,487.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехник коллеж нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн алба нь "Payroll", "Acolous" санхүүгийн программыг ашиглаж байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өөрчлөлт
			Б
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	13,363.9	4,069.7	(9,294.2)
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	221,911.9	244,269.6	22,357.7
Үндсэн хөрөнгө	4,509,054.5	6,421,268.8	1,912,214.3
Нийт хөрөнгө	4,744,330.5	6,669,466.1	1,925,135.6
Өр төлбөр	2,777.9	3,041.2	263.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,741,552.6	6,666,424.8	1,924,872.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,744,330.5	6,669,466.1	1,925,135.6

Авлага дансны үлдэгдэл 4,069.7 мянган төгрөг болж, 9,294.2 мянган төгрөгөөр буурсан нь харилцагч аж ахуйн нэгж байгууллагуудаас авах 9,323.3 мянган төгрөгийн авлагыг барагдуулснаас шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд Нийгмийн даатгалын байгууллагаас авах 242.5 мянган төгрөгийн, 18 хувь хүнээс авах 3,827.2 мянган төгрөгийн авлагатай байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 244,269.6 мянган төгрөг болж, 22,357.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,421,268.8 мянган төгрөг болж, 1,912,214.3 мянган төгрөгөөр өссөн нь Азийн хөгжлийн банкны “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх” төслийн хүрээнд 2,302,875.5 мянган төгрөгийн үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө хандиваар хүлээн авснаас шалтгаалжээ. Үндсэн хөрөнгө акталсан 31,550.0 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 3,041.2 мянган төгрөг болж, 263.3 мянган төгрөгөөр өссөн байна. Өр төлбөр дансны үлдэгдэлд МТ Баянзүрх ХХК-д өгөх 1,842.9 мянган төгрөгийн, Жигүүр катеринг ХХК-д өгөх 0.3 мянган төгрөгийн, ХХОАТ-т өгөх 2.8 мянган төгрөгийн, Нийгмийн даатгалын байгууллагад өгөх 202.4 мянган төгрөгийн, 1 ажилтанд өгөх цалингийн 992.8 мянган төгрөгийн нийт 3,041.2 мянган төгрөгийн өр төлбөртэй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 2,115,166.2 мянган төгрөгөөр буюу 85.3 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна. Энэ нь Азийн хөгжлийн банкны “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх” төслийн хүрээнд 2,302,875.5 мянган төгрөгийн үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө хандиваар хүлээн авснаас шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 1,069,433.9 мянган төгрөгөөр буюу 66.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал шилжүүлэг байна. Энэ нь тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж нэмэгдсэнээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,819,870.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,819,870.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 611,170.0 мянган төгрөгөөр бууруулж, 2,208,700.1 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,200,570.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 2,186,570.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 22,130.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,186,570.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 16,565.1 мянган төгрөг, нийт 2,203,135.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,197,012.9 мянган төгрөгийг зарцуулж, 6,122.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд гадаад төсөл хөтөлбөрөөс 8,130.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс бараа үйлчилгээний зардалд 8,119.5 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 10.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

3.8 Аудитын гол асуудал

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,421,268.8 мянган төгрөг болж, 1,912,214.3 мянган төгрөгөөр өссөн нь Азийн хөгжлийн банкны “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх” төслийн хүрээнд 2,302,875.5 мянган төгрөгийн үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө хандиваар хүлээн авсан нь нөлөөлсөн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехник коллеж нь 2021 онд нийт 3,996,796.3 мянган төгрөгийн 64 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2,875,184.4 мянган төгрөгийн 42 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3-т заасан “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах зөвлөмж өгөв.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

МУЗГ-ын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад 440.0 мянган төгрөгийн конторын тавилга, эд хогшил бэлтгэсэн байгаа нь тогтоолын зарим заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2,391.1 мянган төгрөгийн 1 алдаа зөрчилд тогтоосон төлбөрийн актыг 100.0 хувь, аудитаар өгсөн 9,800.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг 100.0 хувь хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт:

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь

Акт	1	2,391.1	1	2,391.1	-	-	100.0
Албан шаардлага	-	-	-	-	-	-	-
Зөвлөмж	1	9,800.0	1	9,800.0	-	-	100.0
Нийт дүн	2	12,191.1	2	12,191.1	-	-	100.0

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехник коллежийн санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг давтан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,344,497.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2,327,570.6 мянган төгрөгийн алдааг залруулж, 3,706.3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 9,739.3 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 3,481.2 мянган төгрөгийн зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Төслийн хүрээнд хандивласан 2,327,570.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авсан хөрөнгөөр бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төсвийн тухай хуулийн 6 зүйлийн 6.3.2-д “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, санхүүгийн тайлангийн “оршин байх”, “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

Цалинг буруу тооцож олгосонтой холбоотой нийт 2,877.4 мянган төгрөгийн алдаа зөрчилтэй байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн чадвар алдсаны акттай 3 ажилтны цалингаас ХХОАТ чөлөөлөлгүй тооцсоноос 2,253.8 мянган төгрөгийг илүү суутгасан;
2. “Хөдөлмөрийн чадвар алдсаны актын хугацаа нь 2019 оны 02 дугаар сарын 25-нд дууссан 1 ажилтны 2021 оны 1 дүгээр сараас 2021 оны 11 дугаар сарыг дуусталх цалингаас НДШ-ийг хөдөлмөр чадвар алдалтын хувиар тооцон НДШ-д 349.9 мянган төгрөгийг дутуу, ХХОАТ-т 36.9 мянган төгрөгийг илүү, цалингаас нийт 312.9 мянган төгрөгийг дутуу суутгасан;

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.6-д “Ажил олгогч, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд гэрээний дагуу ажиллаж байгаа тэтгэвэр авагч энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 5 дахь заалтад зааснаас бусад төрлийн даатгалд албан журмаар даатгуулна”, “Хувь хүний

орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д "Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө", 22.1.2-т "хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого", 25 дугаар зүйлийн 25.3-т "Суутган төлөгч нь хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлогод албан татвар ногдуулахад холбогдох нотлох баримтыг үндэслэн энэ хуулийн 22.1.2-т заасан чөлөөлөлтийг хасаж тооцно", санхүүгийн "үнэн зөв байдал", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3. 1 ажилтны 12 дугаар сарын цалингийн урамшууллыг 2 дахин олгосноос 196.8 мянган төгрөг, НДШ-д 22.7 мянган төгрөг, ХХОАТ-т 17.4 мянган төгрөг тус тус илүү тооцон цалингаас нийт 156.7 мянган төгрөг илүү олгосон;

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", санхүүгийн "үнэн зөв байдал", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

Он дамжсан авлагатай холбоотой нийт 828.9 мянган төгрөгийн алдаа зөрчилтэй байна. Үүнд:

1. Байгууллага нь Нийгмийн даатгалын байгууллагаас авах 242.5 мянган төгрөгийн, 18 хувь хүнээс авах 3,827.2 мянган төгрөгийн, нийт 4,069.7 мянган төгрөгийн авлагатай байна. Үүнээс 2014 онд үүссэн 6 хувь хүнээс авах 234.5 мянган төгрөгийн, 2017 онд үүссэн 1 хувь хүнээс авах 521.0 мянган төгрөгийн, 2018 онд үүссэн 1 хүнээс авах 73.4 мянган төгрөгийн, нийт 828.9 мянган төгрөгийн он дамжсан авлагатай байна. Он дамжсан авлагын эзэн холбогдогчийг олж тогтоох ажлын хэсэг байгуулан авлагыг төлж барагдуулах арга хэмжээ авагдаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах..." 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", санхүүгийн "үнэн зөв байдал", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

4.3 Албан шаардлага

Байгууллага нь нийт 15 аж ахуй нэгж байгууллагатай холбоотой 9,739.3 мянган төгрөгийн худалдан авалтыг татварын цахим системд бүртгээгүй, и-баримтаар нотлогдохгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т "Бараа ажил үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно", 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал

эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй” заалт, санхүүгийн аудитын “үнэн зөв байдал”, “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй, 85 ширхэг 248,256.9 мянган төгрөгийн биет бус хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна", 6.2.1-д "Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон", "үнэлгээ ба хуваарилалт", "иж бүрэн байх", "үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд санал гаргаж, эрх бүхий байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх

2. Өр төлбөрийн данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Өр төлбөр дансны үлдэгдэлд МТ Баянзүрх ХХК-д өгөх 1,842.9 мянган төгрөгийн, Жигүүр катеринг ХХК-д өгөх 0.3 мянган төгрөгийн, ХХОАТ-т өгөх 2.8 мянган төгрөгийн, Нийгмийн даатгалын байгууллагад өгөх 202.4 мянган төгрөгийн, ажилчдад өгөх 992.8 мянган төгрөгийн, нийт 3,041.2 мянган төгрөгийн өр төлбөртэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах", санхүүгийн аудитын "үнэн зөв байдал", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох заавар журам, Төсвийн тухай хуулийг мөрдөж өр төлбөрийг үүсгэхгүй ажиллах, холбогдох хууль журмын дагуу төлж барагдуулах

3. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Байгууллага нь төсвийн хөрөнгөөр 1 ширхэг 440.0 мянган төгрөгийн өртөгтэй тавилга эд хогшил худалдан авсан нь Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдөр батлагдсан "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.4-т энэ

тогтоол батлагдахаас өмнө "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Засгийн газраас гаргасан тогтоол, шийдвэрийг мөрдөн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт болон аудитын хуулийн этгээдэд 2022 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал:											
1	Хандиваар ирсэн хөрөнгийг худалдан авсан хөрөнгөөр бүртгэсэн	1	2,327,570.6	1	2,327,570.6						
2	Авлага үүсгэсэн, он дамжсан авлагыг барагдуулаагүй	1	828.9			1	828.9				
3	Цалинг буруу тооцоолж олгосон	1	2,877.4			1	2,877.4				
4	Тайлант оны эцэст өр төлбөрийн үлдэгдэлтэй байна	1	3,041.2							1	3,041.2
5	Худалдан авалтыг И баримтаар баталгаажуулаагүй	1	9,739.3					1	9,739.3		
6	Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн хөрөнгө бүртгэлтэй байна	1	-							1	-
7	МУЗГ-ын 43 тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаагүй	1	440.0							1	440.0
Дүн		6	2,344,497.4	1	2,327,570.6	2	3,706.3	1	9,739.3	2	3,481.2
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:											
1	Шилэн дансны цахим хуудсанд бүрэн мэдээлээгүй	1	2,875,184.4							1	2,875,184.4
Дүн		1	2,875,184.4	-	-	-	-	-	-	1	2,875,184.4
Нийт дүн		7	5,219,681.8	1	2,327,570.6	2	3,706.3	1	9,739.3	3	2,878,665.6